



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БОЛОН
АЛТАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЧОЙСҮРЭНГИЙН
БАЯРЖАРГАЛ ТАНАА**

2020.09.03 № ЦА-2020/06-КА-56
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн болон Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Чойсүрэнгийн Баяржаргалын мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сэлэнгэ аймгийн болон Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Ч.Баяржаргал нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020781


Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Ч.Баяржаргалын Сэлэнгэ аймгийн болон Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Ч.Баяржаргалын мөрийн хөтөлбөр /.....² хуудас/-ийг хавсаргав.


Хувийг: Сэлэнгэ аймгийн болон Алтанбулаг сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМАГ БОЛОН АЛТАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЧОЙСҮРЭН ОВОГТОЙ
БАЯРЖАРГАЛЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



Уриа: Орон нутгийн хөгжлийн төлөө, ядуурал, хээл хахуулийн эсрэг, шударга ёсны төлөө

- Төрийн байгууллагын хүнд суртлыг арилгаж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- Төрийн байгууллагад ажиллагсдыг шинээр ажилд сонгон шалгаруулж авахдаа орон нутгийн залуу боловсон хүчнийг сонгож, тэдгээрийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоогоор хангах бодлогыг баримтална.
- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны мэдээллийг ард иргэдэд ил тод, нээлттэй хүргэх чиглэлээр ажиллана.
- Орон нутгийн төрийн албанд эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашигласан албан тушаалтанд хуулийн хариуцлага тооцуулан, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг бүхий хууль, хяналтын байгууллагуудтай хамтран ажиллана.
- Хилийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа хилийн цэрэг, гааль, мэргэжлийн хяналт болон бусад холбогдох байгууллагуудтай хамтарч иргэдийг хүнд суртал чирэгдэлгүйгээр хууль, дүрэм, журмын хүрээнд хөнгөн шуурхай зорчих асуудалд хяналт тавин, иргэдийн санал, хүсэлтийг холбогдох байгууллагуудад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- Ардын уламжлалт эмгүй эмчлэн сувилах арга барилыг нэвтрүүлэх ажлыг дэмжин, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.
- Сумдын Соёлын төвийн үйл ажиллагааг идэвхжүүлж, шинэ уран бүтээл гаргадаг, иргэдийн чөлөөт цагийг зөв зохистой өнгөрөөдөг, урлаг уран сайхны ажиллагааг хөдөө алслагдан байгаа малчин, тариаланчдад хүргэдэг болгоход анхаарч ажиллана.
- Худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагааг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжиж, өөрийн тойргоос сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдэд уламжилна.
- Холбогдох байгууллагуудтай хамтран газар олголтод тавих хяналтыг сайжруулан, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээ авна.
- Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг сайжруулж, байгалийн баялаг болох модыг орон нутгийн иргэдэд тэгш хүртээмжтэйгээр болон шат дамжлагагүйгээр, хуулийн дагуу хяналтын байгууллагын дор бэлтгэдэг болгох, гадагш зарж борлуулдаг үйл ажиллагааг таслан зогсоох талаар идэвх санаачилга гарган ажиллана.
- Газар нутгийн бэлчээр хамгаалах, хөрс талхлагдахаас сэргийлэх, ургамлын гарцыг нэмэгдүүлэх зорилгоор малчидтай хамтарч отор нүүдэл хийх боломжтой

газруудыг судалж, дөрвөн улирлын нүүдлийн газартай болгох асуудлыг холбогдох шатны ИТХ-д оруулан шийдвэрлүүлнэ.

- Суманд үйл ажиллагаа явуулж байгаа нөхөрлөл, хоршоодын үйл ажиллагаатай биечлэн танилцаж, тэдгээрийн үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлээр ажиллана.
- Ард, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор ундны усны худгуудад холбогдох байгууллагаар шинжилгээ хийлгэж, ашиглалтын зэрэглэл тогтоолгох ажлыг зохион байгуулна.
- Сумын хөрсний бохирдлыг арилгуулах асуудлыг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.
- Монгол улсын Хилийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хилийн заставуудын үйл ажиллагаанд туслах, тэнд ажиллаж амьдарч буй албан хаагчид болон тэдгээрийн гэр бүлийг амьдрах нөхцөл бололцоог сайжруулахад анхаарч ажиллана.
- Сум орон нутгийн тохижилтод анхаарч, хоггүй цэвэр сум болгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- Орон нутагт “Залуучууд, эмэгтэйчүүд, ахмад”-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудыг дэмжиж, хамтран ажиллана.
- ОХУ-ын Буриадын районы хилийн дагуух сумуудтай хамтарч ажиллах талаар санал санаачилга гаргаж, хоёр талын хамтарсан уулзалтуудыг зохион байгуулж, туршлага судлах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

Бие даан нэр дэвшигч



Ч.Баяржаргал

2020-07-23